

# ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.04.14



## Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- Улаанбаатар хотын инцфляц 10.1%-тай гарлаа
- Хас банкны 2025 оны 1-р улирлын тайлан гарлаа
- ТОП-100 компани хувьцаагаа олон нийтэд нээлттэй зарлахад хялбар боллоо.
- Ам.долларын ханш 3,500-г давлаа

### МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-1.94%	-4.30%	25.47%
MSE A	-3.29%	-4.40%	20.27%
MSE B	-1.85%	-4.80%	34.89%

2025/04/07 – 2025/04/11

### Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
KHAN	1,027,826,261.00
TTL	529,681,720.00
XAC	304,377,735.61
GLMT	193,298,944.00
SBM	181,812,797.20

2025/04/07 – 2025/04/11

### Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
SOR	12,070.00	65.34%
GOV	268.12	25.06%
JTB	45.00	19.40%
UID	3,500.00	16.55%
AAR	3,337.00	14.99%

2025/04/07 – 2025/04/11

2025 он 04-р сарын 14

Зах зээлийн  
үнэлгээ тэрбум ₮

**12,086**

ТОП-20 индекс

**47,579**

MSE A

**17,552**

MSE B

**14,231**



### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

**4.9%**

2024 он

Инфляц

**9.1%**

2025-03 сар

ГВУН(сая\$)

**4,995.97**

2025-03 сар

Бодлогын

хүү

**12.0%**

ЗГ-ын бондын

өгөөж

**8.5%**

USD/MNT

**3,533.70**

2025-04-13



## Эдийн засгийн мэдээлэл

### АМ.ДОЛЛАРЫН ХАНШ 3,530-Г ДАВЛАА



Дональд Трампын шинэ тарифын бодлоготой холбоотойгоор ам.долларын ханшийн индекс сүүлийн 2.5 жилийн доод түвшинд хүрч, хөгжиж буй орнуудын валютууд чангарлаа. Харин төгрөг ам.долларын эсрэг гурав дахь өдрөө дараалан суларч, 2023 оноос хойш анх удаа 3500 нэгжээс давлаа. Үүнээс гадна, Монгол Улсын 2025 оны эхний хоёр сарын төлбөрийн тэнцэл 742.2 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өмнөх оны ашигтай үзүүлэлтээс эрс дордсон байна.



### УЛААНБААТАР ХОТЫН ИНФЛЯЦЫН БАЙДАЛ (2025 ОНЫ III САР)

2025 оны гуравдугаар сарын эцэст хэрэглээний үнийн индекс жилийн хугацаанд 10.1% өссөн байна. Энэ нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 4.1 нэгж хувиар өндөр үзүүлэлт юм.

#### Инфляцад нөлөөлсөн хүчин зүйлс:

- Импортын бараа (бензин, түлшнээс бусад): инфляцад 2.9 нэгж хувийн нөлөөтэй.
- Дотоодын бараа, бүтээгдэхүүн (мах, хатуу түлшнээс бусад): 5.9 нэгж хувийн нөлөөтэй.
- Цахилгааны үнэ нэмэгдэл (2024 оны 11 сар): инфляцад 1.9 нэгж хувийн нөлөө үзүүлсэн бөгөөд нөлөө нь 2025 оны 11 сар хүртэл үргэлжлэх төлөвтэй.

Сүүлийн жилд дотоодын бараа бүтээгдэхүүний үнэ инфляцад илүү нөлөөлж байгаа нь импортын нөлөө харьцангуй буурсныг харуулж байна. Азийн Хөгжлийн Банк 2025 оны эцэст инфляц 9.1% орчимд хадгалагдана гэж таамаглажээ.



## Дотоодын зах зээлийн мэдээлэл

### ХАС БАНК: ЦЭВЭР АШИГ 44.1 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРСЭН Ч ӨСӨЛТ СААРСАН ДҮНТЭЙ ГАРЛАА

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, системийн нөлөө бүхий банкны нэг болох [MSE:XAC] Хас банк ХК 2025 оны 1-р улирлын санхүүгийн үр дүнгээ олон нийтэд танилцууллаа.

Тайланд дурдсанаар, банкны нийт хөрөнгө 6.18 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны эцсээс -132.1 тэрбум төгрөгөөр буурсан байна. Харин өөрийн хөрөнгө +44.26 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь санхүүгийн бүтцийн хувьд тогтвортой байгааг илтгэж байна.

Цэвэр ашиг 2025 оны 1-р улиралд 44.1 тэрбум төгрөгт хүрч, нэгж хувьцаанд 41.9₮-ийн ашиг ногджээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад +5.0%-ийн өсөлт үзүүлсэн ч өмнөх жилүүдийн өсөлтийн хурдаас (2021Q1–2024Q1 хооронд +33.6%–236.2%) мэдэгдэхүйц саарсан үзүүлэлт боллоо. Хас банк ХК нь санхүүгийн бүтцээ сайжруулах зорилгоор Банкны тухай хуулийн шинэчлэлийн дагуу нэг хувьцаа эзэмшигчийн 20%-ийн босгыг хангах үүднээс “Тэнгэр санхүүгийн нэгдэл” ХХК-ийг өөртөө нэгтгэх үйл явцыг эхлүүлээд байна.

### 1072 ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШГАА УХААЛГААР АШИГЛАХ ЦАГ ИРЛЭЭ

Хувьцааны үнэ хямдардаг улиралд – ухаалаг хөрөнгө оруулалт хийгээрэй

4–5-р сар бол дотоодын хөрөнгийн зах зээлд хувьцааны ханш түр зуур буурдаг үе. Учир нь ихэнх компани ногдол ашиг зарласны дараа ашиг авсан хүмүүс хувьцаагаа зарж, ханш түрхэн буурах хандлагатай байдаг.

Та яг энэ үед 1072 хувьцааны ногдол ашгаа аваад, буурсан ханшаар хямд үнэтэй хувьцаа худалдан авч хөрөнгө оруулалтаа өсгөх боломжтой.

### ТОП-100 ААН-ҮҮД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛЭЭС САНХҮҮЖИЛТ ТАТАХ НӨХЦӨЛ ИЛҮҮ ТААТАЙ БОЛЛОО

2025 оны 4 дүгээр сарын 11-нд Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны ээлжит хуралдаанаар ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээлд оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд санхүүжилт татах боломжийг өргөжүүлэх зорилгоор холбогдох журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулав. Тухайлбал:

- ТОП-100 компанид анх удаа IPO хийхэд хөрөнгийн үнэлгээ заавал хийлгэх шаардлагагүй
- 1 жил хүртэлх хугацаатай 5 тэрбум төгрөг хүртэлх бондыг барьцаа, батлан даалт, андеррайтергүйгээр гаргах боломжтой боллоо
- Хувьцааг нийтэд санал болгон гаргах хүсэлтийг СЗХ ажлын 10 хоногт шийдвэрлэх зохицуулалт нэвтэрч байна.

Эдгээр өөрчлөлт нь дотоодын томоохон аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаагаа тэлэх, санхүүгийн хувьд бэхжих, хөрөнгийн зах зээлээс давтан санхүүжилт татах суурь нөхцөл бүрдүүлэхэд түлхэц өгч, улмаар хөрөнгийн зах зээлийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх юм.




## ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

### Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

Компанийн нэр	Симбол	Бүртгэх өдөр	Тараах өдөр	Нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ	Нийт ногдол ашиг
 ТАВАНТОЛГОЙ ХК	TTL	2025.04.07	2025.05.01-ний өдрөөс эхлэн	6960	366,549,792,000.00
 MMX	MMX	2025.04.07	2025.04.30	100	380,072,100
 INNOVATION INVESTMENT	QPAY	2025.04.08	2025-04-30-ны дотор	20	3,697,783,200.00
 "АРИГ ГАЛ" ХК	EER	2025.04.10	2025-05-30-ны дотор	100	338,933,100.00
 ХАСBANK	XAC	2025.04.10	7 хоногийн дотор	27	28,422,900,000
 ТӨРИЙН БАНК ХҮҮРИЙН ТӨС ХӨРӨНГӨ БАНК	SBM	2025.04.10	2025/04/30-ны өдрийн дотор	63.7	48,099,631,125
 Bayangol Hotel	BNG	2025.04.10	2025-05-01-ний дотор	330	125,773,890
 ТАНДАН ИМВЕСТЬ ЕБС ТӨСВИЙН ХӨРӨНГӨ	TAND	2025.04.10	2025.04.30	1.1	2,200,000,000
 TELECOM MONGOL	MCH	2025.04.11	2025.06.02	1	98,365,240,00
 BASALTWOOL МОНГОЛБАЗАЛТЫ ХК	MBW	2025.04.11	2025-04-30-ны дотор	2.42	136,529,140

## МХБ-д бүртгэлтэй компаниудын ногдол ашгийн бүртгэлийн өдөр

- Дотоодын 46 хувьцаат компани 2024 оны цэвэр ашгаасаа нийт 1.04 их наяд төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ тараахаар шийдвэрлэсэн билээ. Тэгвэл энэ 4-р сарыг 14 өдрийг хүртэл үргэлжлэх ногдол ашиг авах боломжтой хөрөнгө оруулагчдын хувьцааны бүртгэлийн өдрийг та бүхэнд хүргэж байна.
- T+2 төлбөр тооцооны горимын дагуу 2 хоногийн өмнө хувьцааг эзэмшсэн байх ёстой бөгөөд жишээ нь: Монложистик Холдинг ХК-ний ногдол ашгаас авахыг хүсвэл өнөөдөр хувьцааг нь худалдаж авч болох сүүлийн өдөр гэсэн үг юм.

T+2 төлбөрийн тооцооны системийн дагуу явдаг учир бүртгэлийн өдрөөс 2 өдрийн өмнөх эзэмшлээс тооцдог болохы анхаарна уу